



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 1/34

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах сайн дурын  
хэсэг байгуулэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дээсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, Шадар сайдын 2016 оны 34 дүгээр тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны A\185 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн онцлог, гамшиг, ослын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага олгох, шаардлагатай техник багаж хэрэгслээр ханган ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
2. Гамшгаас хамгаалах Сайн дурын ажилтны сургалтын хөтөлбөр гарган сургалт дадлага зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Н.Чанцал/-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнччулуун/, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Н.Чанцал/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

